

199

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

№ 1

Хөвсгөл аймаг

***Компанийн хувьцааг хуваах, нэрлэсэн үнийг тогтоох,
хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зөвтгөх,
компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай***

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, 51.5, 51.6, 62 дугаар зүйлийн 62.1.1 62.1.6, дахь заалт, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрмийн 7.7.5, 7.7.1, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ :

1. Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зөрүүтэй байсныг зөвтгөж, хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хэмжээг 113,286,000 төгрөг болгон өөрчилж, зөрүү 11,060,827 төгрөгийг хуримтлагдсан ашиг данснаас хаах тохируулга бичилт хийсүгэй.
2. Компанийн МХБ-д бүртгэлтэй 1 (Нэг) хувьцааг 100 (Нэг зуун) ширхэг хувьцаанд хөрвүүлэх замаар хувааж, компани нийт 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 10 төгрөг байхаар тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1, 2, 3-т дурдсантай холбогдуулан 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн “Хөвсгөл Алтандуулга” хувьцаат компанийн дүрмийн 4.1, 4.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “Хөвсгөл Алтандуулга” хувьцаат компанийн дүрмийн 4.1 дэх хэсэг:

“4.1. Компанийн зарласан бөгөөд гаргасан хувьцаа нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ”

2/ “Хөвсгөл Алтандуулга” хувьцаат компанийн дүрмийн 4.2 дахь хэсэг:

“4.2. Компани нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 11,328,600 ширхэг энгийн хувьцаатай, 113,286,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно”

5. Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд; мөнхүү өөрчлөлтийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд; Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт тус тус бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Дуламсүрэн)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоолын 1-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн улмаас бий болсон 11,060,827 (113,286,000-102,225,173) төгрөгийн зөрүүг компанийн санхүүгийн тайланд хуримтлагдсан ашгаас тохируулга бичилт хийж, санхүүгийн тайланд тусгахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Одончимэг)-д зөвшөөрсүгэй.
7. Энэхүү тогтоолын 6-д заасан болон Компанийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд зохих ёсоор тусгахыг Гүйцэтгэх захирал (Д.Дуламсүрэн), Ерөнхий нягтлан бодогч (Н.Одончимэг) нарт үүрэг болгосугай.
8. Энэхүү тогтоолын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл(дарга Д.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



**“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 02

Хөвсгөл аймаг

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрмийн 7.8.1, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1. Доржпүрэв овогтой Ганхуяг
- 2. Доржпүрэв овогтой Дуламсүрэн
- 3. Ноов овогтой Ерөөгэрэл
- 4. Манзшир овогтой Зулзаяа
- 5. Очирхүрээ овогтой Тунгалаг
- 6. Төмөр овогтой Мөнхгэрэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1. Лхам овогтой Даваа
- 2. Даваажав овогтой Энхтогтох
- 3. Заяат овогтой Батсүх нарыг тус тус сонгосугай.

ХОЁР.Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДУЛАМСҮРЭН

**“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

№ 03

Хөвсгөл аймаг

**Сонирхлын зөрчилтэй болон их
хэмжээний хэлцэл батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10, 62.1.11. болон 87 мөн 88 дугаар зүйл, 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Тооллогын комиссын тогтоол, хараат бус үнэлгээчин БЭСТЭ ХХК-ийн үнэлгээний тайланг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хөвсгөл Алтандуулга ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигч Тэс трейд ХХК (100 хувь Д.Ганхуягийн эзэмшлийн) болон түүний холбоотой талуудаас авах 1,248,091,589 төг-ийн авлагыг МКМ ХХК (100 хувь Д.Ганхуягийн эзэмшлийн)-ийн өмчлөлийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Батмөнхийн гудамж, “Fintech office” (Финтек оффис) хаягт байрлах оффисын барилгын 8 давхарт байрлах үл хөдлөх хөрөнгөөр тооцож барагдуулах, үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авахтай холбоотой гэрээ хэлцэл хийх, холбогдох өмчийн гэрчилгээг компанийн нэр дээр гаргуулах зэрэгт шаардагдах эрхийг компанийн гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд зөвшөөрсүгэй.

2. Дээрх шийдвэртэй холбоотойгоор МКМ ХХК-тай Тэс трейд ХХК-ийн холбоотой талуудаас авах авлагыг МКМ ХХК-ийн өмчлөлийн оффисын зориулалтын 344.6 м2 талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгөөр тооцож барагдуулах акт үйлдэх эрхийг гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд зөвшөөрсүгэй.

3. Хөвсгөл Алтандуулга ХК-ийн эзэмшлийн 1937 толгой, 151,617,289 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий малыг Тэс трейд ХХК-д бүртгэлийн үнээр худалдаж холбогдох тооцоог 2018 онд багтаан барагдуулахыг гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ДУЛАМСҮРЭН

**Хөвсгөл Алтандуулга ХК-ийн Тэс трейд ХХК ба бусад холбоотой талуудаас авах авлагыг
МКМ ХХК-ийн өмчлөлийн оффисын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгөөр тооцож
барагдуулах тухай акт**

Холбоотой талууд	Авлагын үлдэгдэл, төг 2017.12.31	Авлага үзсэн шалтгаан	Авлагад тооцож МКМ ХХК-иас хүлээж авах үл хөдлөх хөрөнгийн* үнэ, төг
Тэстрейд ХХК 100% Д.Ганхуягийн эзэмшил	941,407,513	2012-2017 онд үүссэн, компани хоорондын бэлэн болон бэлэн бус мөнгөн гүйлгээ	
Хотолшим ХХК 100% Д.Ганхуягийн эзэмшил	306,684,076	Малтай холбоотой зардлуудыг энэ компаниас авах авлагаар хуримтлуулж бүртгэсэн	
НИЙТ	1,248,091,589		1,248,091,589

* - Авлагад тооцож МКМ ХХК-аас хүлээж авах үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл

Өмчлөл МКМ ХХК, 100% Д.Ганхуягийн эзэмшил

Зориулалт

Оффис

УБ хот, Сүхбаатар дүүрэг, Батмөнхийн гудамж, "FinTech office" оффисын 8 давхар

Байршил

Талбай, м

344.6

Кв.м-ийн үнэ, төг

Нийт үнэ, төг

1,248,091,589

Зөвшөөрсөн:



Тэстрейд ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Чулуунчимэг

Тэстрейд ХХК-ийн Нягтлан бодогч Н.Одончимэг

Хотолшим ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Ганхуяг

Хотолшим ХХК-ийн Нягтлан бодогч Н.Одончимэг

Хөвсгөл Алтандуулга ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэн

Хөвсгөл Алтандуулга ХК-ийн Нягтлан бодогч Н.Одончимэг

